

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Байгуулагдсан: 2012

ХК болсон: 2019 (МХБ I ангилал)

Хувьцаа эзэмшигчид table with columns: Хувьцаа эзэмшигчид, %, Хойш

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Түз-ийн бүрэлдэхүүн table with columns: Түз-ийн бүрэлдэхүүн, 6, 5

Менежмент:

Гүйцэтгэх захирал: А.Отгондарь

/23+ жилийн туршлага/

LinkedIn: Otgondari Agvaandorj

Гүйцэтгэх удирдлагын баг:

16 гишүүн

Ажилтны тоо: 265

Эрэгтэй 55%, Эмэгтэй 45% /дундаж нас 35/

ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ХАРЬЦАА

Онцлох санхүүгийн харьцаа table with columns: Харьцаа, 2023, 2024

2024 оны онцлог үйл явдал

-Шингэн болон хуурай хүнсний үйлдвэрийг нэгтгэсэн нийт 6,300м2 MFC 2.0 үйлдвэр ашиглалтад оров.

- Компанийн засаглал, хараат бус хяналтыг сайжруулж, ТУЗ-ийн бүрэлдэхүүн шинэчлэгдэн хараат бус 5 гишүүнтэй болов.

- Швейцарт төвтэй аудит, магадлан итгэмжлэлийн SGS байгууллагын өндөр шалгуурыг давж, олон улсын стандартуудыг амжилттай хэрэгжүүлснээ баталгаажуулав.

- Төв Азийн зах зээл рүү бизнесээ тэлж, экспортоо нэмэгдүүлэв.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Эрчим хүч: Эрчим хүчний хэрэглээгээ автоматаар тохируулдаг инвертертэй тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

Нарны эрчим хүч: ашиглан орчны гэрэлтүүлгийг шийдэж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах боломжийг нэмэгдүүлэв.

Хуванцрын хэрэглээ: "Экос" ус, "Энжжин" цайны савлагааг шинэчилж хуванцрын хэмжээ, цаасны хэрэглээг бууруулснаар жилд 51 тонн хог хаягдал гарахаас сэргийлж ажиллаа.

Саарал усны дахин ашиглалт: Цэвэр усны хэрэглээг бууруулж, үйлдвэрийн цэвэрлэгээ, ахуйн хэрэглээ, ногоон байгууламжийн усалгаанд саарал ус ашиглаж байна.

ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН НИЙЦЭЛ

ISO 9001:2015 (Чанарын удирдлагын тогтолцоо)

FSSC 22000:2018 (Хүнсний аюулгүй байдал)

ISO 14001:2015 (Байгаль орчны удирдлага)

ISO 17025 (Лаборатори)




КОМПАНИЙН ТУХАЙ

Монос Группийн охин компани болох Монос Хүнс ХК нь 2012 онд хүн амын эрүүл мэндийг дэмжих хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэн худалдаалах зорилгоор байгуулагдсан.



БОРЛУУЛАЛТ


Борлуулалт table with columns: Тэрбум ₮, 2022, 2023, 2024, YoY%



Компанийн орлогын харьцааны хувьд шингэн хүнс 75%, хуурай хүнс 25%-г бүрдүүлдэг бөгөөд шингэн хүнсний хувьд Монос Хүнс ХК 2024 онд 10 сая литр бүтээгдэхүүн борлуулсан байна.

ХУВЬЦААНЫ ТАЛААР

Хувьцааны ханш +27% table with columns: Хувьцааны ханш, P/E ratio, P/B ratio



ЯГААД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

Тогтвортой өсөлттэй бизнес модель: Олон жил тогтвортой өсөлттэй ажиллаж, зах зээлд байр сууриа бататгасан.

Ногдол ашиг тогтмол тараадаг: 2019 онд IPO хийснээс хойш 2019-2022, 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн бөгөөд нийт ₮4.1 тэрбумыг ногдол ашигт олгоод байна.

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн голлох үзүүлэлтүүд table with columns: Тэрбум ₮, 2022, 2023, 2024, YoY%

Зах зээлд бүтээгдэхүүний эрэлт нь нийлүүлэлтийн боломжоос давж борлуулалтын өсөлтийн хурд 2022 оноос саарч ирсэн бөгөөд хүчин чадлаа нэмэх зорилгоор 2023 онд ₮27 тэрбумын урт хугацаат зээл авч шинэ үйлдвэрт хөрөнгө оруулалт хийсэн.

Компани богино хугацаанд өрийн дарамтаас гарах бодлого баримтлан ашигт ажиллагааг нэмэгдүүлэн 2024 онд ₮20 тэрбумын урт хугацаат зээлийг эргэн төлснөөр эргэлтийн хөрөнгө 55% буурсан үзүүлэлттэй гарсан байна.

2024 онд MFC 2.0 шинэ үйлдвэр ашиглалтад орсноор үйлдвэрлэлийн хүчин чадал 3 дахин нэмэгдэн, цаашид бүтээгдэхүүний төрөлжилт, борлуулалтын орлого нэмэгдэн, бизнесийн өсөлтийг тогтмол хадгалах төлөвтэй байна.

Зах зээлийн үнэлгээ 2024 оны сүүлийн байдлаар ₮36.3 тэрбум.

Хувьцааны өдрийн дундаж арилжааны хэмжээ ₮6.8 сая.

Хувьцааны ханшийн хувьд Ковидын дараа буюу 2022 оны II сард түүхэн дээд ханш ₮149.70-д хүрч байсан бол сүүлийн 52 долоо хоногийн ханшийн хэлбэлзэл нь ₮77.46 - ₮96.61 хооронд байлаа.

Тархалтын судалгаагаар хувьцаа эзэмшигчдийн дийлэнх нь 35-с дээш насны иргэд буюу эрүүл мөндөд хөрөнгө оруулалт хийн эрүүл, чанартай хүнсний бүтээгдэхүүн түлхүү сонгодог хэрэглэгчдийн сегмент байна.

Инновацилаг: Шинэ бүтээгдэхүүний хөгжүүлэлт тогтмол хийдэг, бүх насны хэрэглэгчдэд зориулсан бүтээгдэхүүний төрлүүдтэй.

Гадаад зах зээл рүү нэвтэрсэн: Бүгд найрамдах Киргиз улс дахь Монос Кейджи ХХК-тай дистрибуторын гэрээ байгуулж, тухайн зах зээлд 28 нэр төрлийн бүтээгдэхүүнийг борлуулж эхлээд байна.